



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/31

Арвайхээр сум

Өвс, тэжээл хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.5, 32.1.6 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2024 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилт хүндрэх төлөвтэй байгаа Баян-Өндөр, Бат-Өлзий, Богд, Баруунбаян-Улаан, Баянгол, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Хужирт, Есөнзүйл, Өлзийт, Сант, Нарийнтээл, Тарагт, Төгрөг, Хайрхандулаан, Уянга, Арвайхээр сумдад аймгийн аюулгүйн нөөцөөс хөнгөлөлттэй олгох ногоон тэжээлийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт хүндрэх онцгой эрсдэл үүсэж, өвлийг хохирол багатай даван туулах зорилгоор сумдын өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа (Д.Одонбаяр)-д үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0067

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр
сарын 27-ны өдрийн 113 дугаар
захирамжийн хавсралт



АЙМГИЙН АЮУЛГҮЙН НӨӨЦӨӨС ХӨНГӨЛӨЛТТЭЙ
ОЛГОХ НОГООН ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

д/д	Сумын нэр	Малчин өрхийн тоо	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (мянган төгрөг)	Нийт үнэ (мянган төгрөг)
1	Баян-Өндөр	914	850	8.0	6,800,000
2	Бат-Өлзий	1532	750	8.0	6,000,000
3	Баруунбаян-Улаан	518	1000	8.0	8,000,000
4	Баянгол	854	750	8.0	6,000,000
5	Гучин-Ус	447	1500	8.0	12,000,000
6	Есөнүйл	723	1000	8.0	8,000,000
7	Өлзийт	638	750	8.0	6,000,000
8	Зүүнбаян-Улаан	1220	1000	8.0	8,000,000
9	Богд	1150	1000	8.0	8,000,000
10	Нарийнтээл	597	500	8.0	4,000,000
11	Сант	897	1000	8.0	8,000,000
12	Тарагт	999	500	8.0	4,000,000
13	Төгрөг	640	1000	8.0	8,000,000
14	Уянга	1872	1200	8.0	9,600,000
15	Хайрхандулаан	727	700	8.0	5,600,000
16	Хужирт	1270	1500	8.0	12,000,000
17	Арвайхээр	1084	500	8.0	4,000,000
		16082	15500		124,000,000

-оОо-